

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2024/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2024.03.11

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Аудитор: С.Цэвээнсүрэн

Утас: 99441515 Цахим хаяг: Tseveensurens@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/.....	2
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан /төгрөгөөр/.....	2
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/.....	3
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/.....	4
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	4
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	6
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	6
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	6
3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	7
4. Аудитын тайлан.....	10
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.2 Материаллаг байдал.....	10
4.4.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. Аудитын илрүүлэлт.....	12
5.1 Албан шаардлага.....	12
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/.....	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.03.15 № 2/84

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд өөрийн орлогоор 5.500.0 мянга, Иргэний нисэхийн ерөнхий газраас 986.912.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт зардлыг 992.412.4 мянган төгрөг байхаар баталсан ба гүйцэтгэлээр 74.008.2 мянган төгрөгийн орлого олж, 1.213.906.0 мянган төгрөг зарцуулж, 1.139.897.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 нийтлэг зорилт, арга хэмжээний хүрээнд 9 зорилт, 33 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд 83.93 хувьтай хэрэгжүүлсэн байна. Баянхонгор нисэх буудалд 2023 онд онцгой үүргийн нислэг 5, түргэний нислэг 20, захиалгат нислэг 48, дадлагын нислэг 6, нийт 79 нислэг үйлдсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style, crossing the stamp.

1.Аудитын санал дүгнэлт

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	25,206,142.95	29,418,248.55
1.1.2	Дансны авлага	0	4,509,802.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,143,450.04	17,454.53
1.1.4	Бусад авлага	5,821,924.79	1,894,143.73
1.1.6	Бараа материал	42,955,991.45	52,728,096.50
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	516,042.00	516,038.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	75,643,551.23	89,083,783.31
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,288,771,076.07	1,021,535,100.79
1.2.2	Биет бус хөрөнгө	1,068,485,543.14	1,050,690,984.79
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	10,668,596.73	7,729,456.77
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,367,925,215.94	2,079,955,542.35
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,443,568,767.17	2,169,039,325.66
2.1.1.3	Татварын өр	0	230,268.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0	388,168.17
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0	618,436.17
2.2	Өр төлбөрийн нийт дүн	0	618,436.17
2.3	Эздийн өмч	1,886,462,330.77	1,703,099,408.77
2.3.1	Өмч: - төрийн	1,030,960,000.00	1,030,960,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	855,502,330.77	672,139,408.77
2.3.9	Хуримтлагдсан ашиг	557,106,436.40	465,321,480.72
	Эздийн өмчийн дүн	2,443,568,767.17	2,168,420,889.49
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,443,568,767.17	2,169,039,325.66

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	7,653,274.55	6,878,343.27
2	Борлуулалтын өртөг	884,202,652.80	1,147,873,865.90
3	Нийт ашиг (алдагдал)	-876,549,378.25	-1,140,995,522.63
4	Түрээсийн орлого	454,545.45	0
5	Хүүний орлого	0	20,444.45
8	Бусад орлого	977,669,262.17	67,109,382.60
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,500,000.00	3,000,000.00
12	Бусад зардал	84,983,425.84	63,032,182.10
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	15,091,003.53	-1,139,897,877.68
19	Орлогын татварын зардал	0	0
20	Татварын дараах ашиг (алдагдал)	15,091,003.53	-1,139,897,877.68
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0	0
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	15,091,003.53	-1,139,897,877.68
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0

24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0	0
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0	0
26	Бусад олз гарз	0	0
27	Орлогын нийт дүн	0	0
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	15,091,003.53	-1,139,897,877.68

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,030,960,000.00	855,502,330.77	557,106,436.40	2,443,568,767.17
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0
3	Залруулсан үлдэгдэл	1,030,960,000.00	855,502,330.77	557,106,436.40	2,443,568,767.17
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0
6	Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0	0
7	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0
9	2022 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,030,960,000.00	855,502,330.77	557,106,436.40	2,443,568,767.17
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0
11	Залруулсан үлдэгдэл	1,030,960,000.00	855,502,330.77	557,106,436.40	2,443,568,767.17
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	-275,147,877.68	-275,147,877.68
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0
14	Өмчид гаргасан өөрчлөлт	0	-183,362,922.00	183,362,922.00	0
15	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0
17	2023 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,030,960,000.00	672,139,408.77	465,321,480.72	2,168,420,889.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	835,040,576.10	881,277,286.26
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,532,377.80	2,160,738.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	822,404,600.00	864,750,000.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	8,103,598.30	14,366,548.26
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	853,044,766.65	877,085,625.11
1.2.1	Ажиллагчдад төлсөн	408,892,778.03	441,659,872.75
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	107,100,306.49	129,156,868.09
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	142,852,955.00	118,610,985.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	34,730,198.82	38,495,856.11
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	0	1,876.51
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	70,944,500.00	66,747,520.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	47,505,429.43	52,159,998.18
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	16,106,615.88	0
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	24,911,983.00	30,252,648.47
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-18,004,190.55	4,191,661.15
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	20,444.45
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0	20,444.45
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	20,444.45
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-18,004,190.55	4,212,105.60
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-18,004,190.55	4,212,105.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	43,210,333.50	25,206,142.95
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	25,206,142.95	29,418,248.55

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны гүйцэтгэл	2023 оны Тодотгол		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА	848,492,483.7	992,412,400.0	866,923,018.6	125,489,381.4	114.5
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	848,492,483.7	992,412,400.0	866,923,018.6	125,489,381.4	114.5
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,180,483.7	986,222,400.0	866,923,018.6	119,299,381.4	113.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	486,339,476.2	622,440,900.0	541,053,806.9	81,387,093.1	115.0
1 Үндсэн ба нэмэгдэл цалин	412,374,476.2	545,304,800.0	473,688,806.9	71,615,993.1	115.1

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Унаа хоолны хөнгөлөлт	73,965,000.0	77,136,100.0	67,365,000.0	9,771,100.0	114.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		57,501,305.7	82,033,700.0	58,795,303.9	23,238,396.1	139.5
1	Тэтгэврийн даатгал	40,804,011.7	52,907,500.0	35,028,568.1	17,878,931.9	151.0
2	Тэтгэмжийн даатгал	4,804,894.4	6,224,400.0	5,279,036.6	945,363.4	117.9
3	ҮОМШ-ийн даатгал	2,743,867.9	9,208,100.0	8,502,265.5	705,834.5	108.3
4	Ажилгүйдлийн даатгал	831,684.7	1,244,900.0	907,766.8	337,133.3	137.1
5	Эрүүл мэндийн даатгал	8,316,847.0	12,448,800.0	9,077,667.0	3,371,133.1	137.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		57,741,282.9	74,555,700.0	70,177,554.1	4,378,145.9	106.2
1	Гэрэл, цахилгаан	27,131,232.9	34,275,500.0	29,999,904.1	4,275,595.9	114.3
2	Түлш, халаалт	30,610,050.0	38,881,400.0	38,877,650.0	3,750.0	100.0
3	Цэвэр, бохир ус	0.0	1,398,800.0	1,300,000.0	98,800.0	107.6
Хангамж, бараа материалын зардал		77,209,055.9	81,215,900.0	74,993,852.0	6,222,048.0	108.3
1	Бичиг хэрэг	1,385,000.0	1,680,400.0	1,680,000.0	400.0	100.0
2	Тээвэр, шатахуун	62,434,000.0	58,734,900.0	58,732,000.0	2,900.0	100.0
3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,148,965.9	13,476,600.0	8,295,952.0	5,180,648.0	162.4
4	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,944,000.0	3,970,300.0	3,582,400.0	387,900.0	110.8
5	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,297,090.0	3,353,700.0	2,703,500.0	650,200.0	124.1
Нормативт зардал		17,285,000.0	0.0	0.0	0.0	0.0
1	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,285,000.0	0.0	0.0	0.0	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал		106,158,963.0	82,682,000.0	81,959,455.0	722,545.0	100.9
1	Багаж, техник, хэрэгсэл	68,880,333.0	30,942,600.0	30,872,890.0	69,710.0	100.2
1	Тоног төхөөрөмж	38,650,033.0	8,349,000.0	8,340,390.0	8,610.0	100.1
2	Автомашин	6,402,000.0	9,531,900.0	9,531,520.0	380.0	100.0
3	Аэродром	21,929,300.0	6,856,400.0	6,805,600.0	50,800.0	100.7
4	Гал унтраах зардал	1,899,000.0	6,205,300.0	6,195,380.0	9,920.0	100.2
5	Хөдөлмөр хамгааллын зардал	6,715,500.0	16,687,400.0	16,044,315.0	643,085.0	104.0
6	Урсгал засвар	30,563,130.0	35,052,000.0	35,042,250.0	9,750.0	100.0
Томилолт, зочны зардал		20,300,400.0	13,985,100.0	13,985,100.0	0.0	100.0
1	Дотоод албан томилолт	20,300,400.0	13,985,100.0	13,985,100.0	0.0	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		19,157,148.0	23,455,300.0	20,482,070.2	2,973,229.8	114.5
1	Харуул, хамгаалалтын зардал	1,513,100.0	2,012,500.0	1,468,700.0	543,800.0	137.0
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,185,052.0	8,833,200.0	8,829,778.2	3,421.8	100.0
3	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,833,600.0	3,833,700.0	3,263,600.0	570,100.0	117.5
4	Даатгалын үйлчилгээ	6,192,500.0	7,008,900.0	6,192,500.0	816,400.0	113.2
5	Тээврийн хэрэгслийн татвар	606,204.0	758,500.0	0.0	758,500.0	100.0
6	Газрын төлбөр	715,392.0	768,500.0	546,192.0	222,308.0	140.7
7	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	111,300.0	240,000.0	181,300.0	58,700.0	132.4
Бараа үйлчилгээний бусад зардал		3,487,852.0	5,853,800.0	5,475,876.5	377,923.5	106.9
1	Бараа үйлчилгээний бусад зардал	3,487,852.0	4,603,800.0	4,345,876.5	257,923.5	105.9
2	Сургалт семинар	0.0			0.0	
3	Дотоод сургалт	650,000.0	1,250,000.0	1,130,000.0	120,000.0	110.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,312,000.0	6,190,000.0	0.0	6,190,000.0	100.0

1	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,812,000.0	4,500,000.0	0.0	4,500,000.0	100.0
2	Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж				0.0	100.0
3	Эмчилгээний төлбөр	1,500,000.0	1,690,000.0	0.0	1,690,000.0	100.0
НИЙТ ОРЛОГЫН ДҮН		13,265,976.1	5,500,000.0	6,620,258.0	-1,120,258.0	83.1
1	Буулт, хөөрөлтийн орлого	5,162,377.8	3,000,000.0	2,160,738.0	839,262.0	138.8
2	Зорчигч үйлчилгээний орлого		0.0		0.0	
3	Бусад орлого	8,103,598.3	2,500,000.0	4,459,520.0	-1,959,520.0	56.1
	Төсвөөс санхүүжих дүн	821,804,600	986,912,400	864,750,000	122,162,400.0	114.1

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын зорилго нь “Аюулгүй ажиллагааг эрхэмлэн ард түмний итгэл найдварыг алдахгүй, түргэн шуурхай үйлчилгээг ард түмэнд хүргэж ажиллах” -д оршино.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Иргэний нисэхийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж эрх зүйн орчин бүрдүүлэх, иргэний нисэхийн болон аюулгүй байдлыг хангах” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Иргэний нисэхийн ерөнхий газар Төрийн өмчит Баянхонгор аймаг дахь салбар гэсэн статустай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь 1956 оны 06 дугаар сарын 18-ны өдөр байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Аймгийн Засаг Даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлыг олон улсын жишигт ойртуулан ажиллах тухай тусгуулан ажиллаж байна

Тус байгууллага нь Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа байгууллага бөгөөд тайлант онд 992,412.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 866,923.0 мянган төгрөгийг зарцуулж, 125,489.4 мянган төгрөг буюу нийт зардлын 12.6 хувийг хэмнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл, баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 274,529.4 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар *буурсан* байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	Б	1	2	3=2-1
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	75,643,551.23	89,083,783.31	13,440,236.08
1	Мөнгөн хөрөнгө	25,206,142.95	29,418,248.55	4,212,105.60
2	Авлага	6,965,374.83	6,421,400.26	-543,974.57
3	Бараа материал	42,955,991.45	52,728,096.50	9,772,105.05
4	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО	516,042.00	516,038.00	-4
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,367,925,215.94	2,079,955,542.35	-287,969,673.59
5	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,288,771,076.07	1,021,535,100.79	-267,235,975.28
6	Биет бус хөрөнгө	1,068,485,543.14	1,050,690,984.79	-17,794,558.35
7	Хойшлогдсон татварын хөрөнгө	10,668,596.73	7,729,456.77	-2,939,139.96
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,443,568,767.17	2,169,039,325.66	-274,529,441.51
8	ӨР ТӨЛБӨР	0	230,268.00	230,268.00
9	Бусад богино хугацаат өр төлбөр	0	388,168.17	388,168.17
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0	618,436.17	618,436.17

	Эздийн өмч	1,886,462,330.77	1,703,099,408.77	-183,362,922.00
10	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	855,502,330.77	672,139,408.77	-183,362,922.00
11	Хуримтлагдсан ашиг	557,106,436.40	465,321,480.72	-91,784,955.68
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,443,568,767.17	2,169,039,325.66	-274,529,441.51

Эх сурвалж: 2023 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 29,418.2 мянган төгрөг болж 4,212.1 мянган төгрөгөөр өссөн нь Иргэний нисэхийн ерөнхий газраас олгосон санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг арилжааны банкин дахь харилцах дансанд үлдэгдлээр байршуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 6,421.4 мянган төгрөг болж 543.9 мянган төгрөгөөр буурсан нь 2017 онд үүссэн урт хугацаат авлагаас төлөгдсөн байна.

Авлага дансны үлдэгдэлд “Авиа” компаниас авах буулт, хөөрөлтийн авлага 4.509.8 мянган төгрөг, хамтран ажиллагч байгууллагаас авах НӨАТ-ын авлага 17.4 мянган төгрөг, ажилчдаас авах цалингийн зөрүүний авлага 235.1 мянган төгрөг, мөн 2017 онд үүссэн хувь хүнээс авах авлагын үлдэгдэл 1.659.0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 52.728.1 мянган төгрөг болж 9.772.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд өөрийн хөрөнгөөр 167.645.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Иргэний нисэхийн үндэсний төвөөс үнэ төлбөргүй хүлээн авсан 63.509.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 221.383.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Урьдчилж төлсөн зардал 516.0 байгаа нь тайлант оны тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгалын үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,021,535.1 мянган төгрөг болж 267.236.0 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд үүссэн элэгдлийн зардал байна.

Биет бус хөрөнгө 1.050.691.0 мянган төгрөг болж, тайлант хугацааны элэгдлийн зардал 17,794.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хойшлогдсон татварын хөрөнгө данс нь 7,729.5 мянган төгрөг байгаа нь үндсэн хөрөнгийн хойшлогдсон НӨАТ-ын үлдэгдэл байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл тайлант хугацаанд 618.4 мянган төгрөгөөр үүссэн нь “Авиа” компанид өгөх НӨАТ-ын өглөг 230.6 мянган төгрөг, харилцагч байгууллагад өгөх бараа материалын өглөг 388.2 мянган төгрөг байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 1.703.099.4 мянган төгрөг болж 183.362.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн өөрчлөлттэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 672.139.4 мянган төгрөг болж, 183.362.9 мянган төгрөгөөр буурсан байна.

3.4. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Иргэний нисэхийн ерөнхий газраас Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны орлого, зарлагын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 5.500.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 992.412.4 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 6.620.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 866.923.0 мянган төгрөгийн зардал гарган, Иргэний нисэхийн ерөнхий газраас 864.750.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Орлогын эх үүсвэр нь буулт хөөрөлтийн орлого, бусад орлогоос бүрджээ.

Нийт орлогын гүйцэтгэл 6.620.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 1.120.3 мянган төгрөг буюу 20.3 хувиар өссөн нь бусад орлого 1.959.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 866.923.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 125.489.4 мянган төгрөг буюу 114.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайланд онд цалин, нийгмийн даатгалын шимтгэл 104.715.5 мянган төгрөг хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тус байгууллагын орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны Тодотгол		2023 оны Тодотгол		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА	1,024,699,800.0	848,492,483.7	992,412,400.0	866,923,018.6	125,489,381.4	114.5
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	1,024,699,800.0	848,492,483.7	992,412,400.0	866,923,018.6	125,489,381.4	114.5
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,018,699,800.0	845,180,483.7	986,222,400.0	866,923,018.6	119,299,381.4	113.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	601,220,800.0	486,339,476.2	622,440,900.0	541,053,806.9	81,387,093.1	115.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,152,600.0	57,501,305.7	82,033,700.0	58,795,303.9	23,238,396.1	139.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,552,800.0	57,741,282.9	74,555,700.0	70,177,554.1	4,378,145.9	106.2
Хангамж, бараа материалын зардал	80,372,100.0	77,209,055.9	81,215,900.0	74,993,852.0	6,222,048.0	108.3
Нормативт зардал	17,285,000.0	17,285,000.0	0.0	0.0	0.0	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	113,591,300.0	106,158,963.0	82,682,000.0	81,959,455.0	722,545.0	100.9
Томилолт, зочны зардал	18,000,000.0	20,300,400.0	13,985,100.0	13,985,100.0	0.0	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,625,200.0	19,157,148.0	23,455,300.0	20,482,070.2	2,973,229.8	114.5
Бараа үйлчилгээний бусад зардал	5,900,000.0	3,487,852.0	5,853,800.0	5,475,876.5	377,923.5	106.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,000,000.0	3,312,000.0	6,190,000.0	0.0	6,190,000.0	100.0
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	5,500,000.0	13,265,976.1	5,500,000.0	6,620,258.0	-1,120,258.0	83.1
1 Буулт, хөөрөлтийн орлого	3,000,000.0	5,162,377.8	3,000,000.0	2,160,738.0	839,262.0	138.8
2 Бусад орлого	2,500,000.0	8,103,598.3	2,500,000.0	4,459,520.0	-1,959,520.0	56.1

Эх сурвалж: Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны орлого, зардлын төлөвлөгөө

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг дарга Д.Мөнхжаргал танд танилцуулж байна

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмч, хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг дарга Д.Мөнхжаргал, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Одончимэг нар зурсан байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,044.651.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15.669.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,752.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны зардлын дүн 1,044,651.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,669.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,752.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлснээр нийт 119,299.4 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ. Үүнд:

- Нислэгийн мэдээллийн ажилтны 1 орон тоо ажиллаагүй, Фириводын техникчид 3 сарын цалингүй чөлөө олгосон, ажилчдын илүү цагийг 50 хувиар бодож олгосноор цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 104,625.5 мянган төгрөгөөр хэмнэсэн.

- Байр ашиглалтын зардлыг 4,378.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 6,222.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 722.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 2,973.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 377.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан мэдээллийг шалгахад шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1. тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлээгүй, 6.4.6. худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, 6.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр заалтад холбогдох тайлант оны тушаал, шийдвэрүүдийг ил тод байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.6, 6.4.8-д заасан мэдээллүүдийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар: Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, аудитаар 1.737.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлж, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	1.737.2	1	1.737.2	100%
Нийт дүн	1	1.737.2	1	1.737.2	100%

Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын статистик мэдээ

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын даргаар ажиллаж байсан Н.Баярхүүгийн 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн Б/35 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн жолооч Б.Хүрэлбаатарт Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 131/ШШ2019/00935 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлд 1121211.28 төгрөгийг 2020 онд Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын төсвөөс олгосон бөгөөд тус авлага бүрэн барагдаагүй байна, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Иймд 2024 онд авлагыг бүрэн барагдуулж ажиллах талаар арга хэмжээ авч ажиллахыг байгууллагын удирдлагад зөвлөж ажиллаа.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11.588.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, зөрчил арилгах 4 албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчил нь гүйцэтгэлийн шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгөв.

5.1 Албан шаардлага

5.1.1. Шатахууны тайланг анхан шатны баримттай тулгахад анхан шатны баримт болон жоолоочийн замын тооцооны хуудсыг үндэслэлгүй зарцуулсан 11.588.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид шатахууны зарцуулалтад шаардах хуудас, жолоочийн замын тооцооны хуудсыг үнэн зөв хөтлөх, эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, анхан шатны баримтыг үйлдсэн зөвшөөрсөн, шалгасан ажилтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.1.2. Тус байгууллагын ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн улсын дугаарыг Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солиогүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4 дэх “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг арилгаж, автотээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг солих албан шаардлага хүргүүлэв.

5.1.3. Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь тайлант оны батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөө, өмнөх оны аудитын тайлан дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, тайлант онд гарсан тушаал, шийдвэрүүдийн мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг арилгаж, шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, албан шаардлага өгөв.

5.1.4. Байгууллагын 2023 оны эд хөрөнгийн тооллогын тайланг үзэхэд тооллогын үлдэгдлийг баталгаажуулсан тушаал гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид эд хөрөнгийн тооллого явуулж, үлдэгдлийг баталгаажуулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудал	БНА-2024/01/НА-СТА-ТӨА	Шатахууны тайланг анхан шатны баримттай тулгахад анхан шатны баримт болон жоолоочийн замын тооцооны хуудсыг үндэслэлгүй зарцуулсан 11.588.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.	Цаашид шатахууны зарцуулалтад шаардах хуудас, жоолоочийн замын тооцооны хуудсыг үнэн зөв хөтлөх, эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, анхан шатны баримтыг үйлдсэн зөвшөөрсөн, шалгасан ажилтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.	1	11.588.0					1	11.588.0		
2	Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудал	БНА-2024/01/НА-СТА-ТӨА	Тус байгууллагын ажиглаж байгаа тээврийн хэрэгслийн улсын дугаарыг төрийн хэмнэлтийн хуулийн дагуу бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солиогүй байна.	Зөрчлийг арилгаж, автотээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг солих албан шаардлага хүргүүлэв.	1	0					1	0		
3	Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудал	БНА-2024/01/НА-СТА-ТӨА	Байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланг үзэхэд тооллогын үлдэгдлийг баталгаажуулсан тушаал гаргаагүй байна.	Цаашид эд хөрөнгийн тооллого явуулж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулж эвших албан шаардлага хүргүүлэв.	1	0					1	0		
4	Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудал	БНА-2024/01/НА-СТА-ТӨА	Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь тайлант оны батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөө, өмнөх оны аудитын тайлан дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, тайлант онд гарсан тушаал, шийдвэрүүдийн мэдээллийг ил тод байршуулаагүй байна.	Зөрчлийг арилгаж, шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, албан шаардлага өгөв.	1	0					1	0		
ДҮН					4	11.588.0					4	11.588.0		



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 232/А0571212/БНА-2024/01/
НА-СТА-ТБА

Номгон

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахууны тайланг анхан шатны баримттай/тулгахад анхан шатны баримт болон жоолоочийн замын тооцооны хуудсыг үндэслэлгүй зарцуулсан 11.587.957 (Арван нэгэн сая таван зуун наян долоон мянга есөн зуун тавин долоон төгрөг)-ийн зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Цаашид шатахууны зарцуулалтад шаардах хуудас, жолоочийн замын тооцооны хуудсыг үнэн зөв хөтлөх, эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, анхан шатны баримтыг үйлдсэн зөвшөөрсөн, шалгасан ажилтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж ажиллах. Хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох

5040703

баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын дарга Д.Мөнхжаргал, нягтлан бодогч Д.Одончимэг нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

С.ЦЭВЭЭНСҮРЭН



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 33 /АУГА-2024/ БНА-2024/01/
НА-СТА-ТӨА

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн улсын дугаарыг Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар солиогүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4 дэх “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” заалтыг мөрдөж ажиллаагүй байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


5040707

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын дарга Д.Мөнхжаргал, нягтлан бодогч Д.Одончимэг нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АУДИТОР:  С.ЦЭВЭЭНСҮРЭН



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 237/АОСГ1212/БНА-2024/01/
НА-СТА-ТӨА

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим сайтад байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөө, өмнөх оны аудитын тайлан дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, тайлант онд гарсан тушаал, шийдвэрүүдийн мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.1 дэх “Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт”, 6.4.6 дахь “Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн”, 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 6.4.9 дэх “Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл” заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа,

5040709

зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

Зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын дарга Д.Мөнхжаргал, нягтлан бодогч Д.Одончимэг нарт даалгав^{1,2}.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

С.ЦЭВЭЭНСҮРЭН



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 265/00571212/ВНА-2024/01/ Номгон
НА-СТА-ТӨА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 2023 оны эд хөрөнгийн тооллогын тайланг үзэхэд тооллогын үлдэгдлийг баталгаажуулсан тушаал гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


Зөрчлийг арилгаж, хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


5040713

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын дарга Д.Мөнхжаргал, нягтлан бодогч Д.Одончимэг нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  **Б.МӨНХБАТ**

АУДИТОР:  **С.ЦЭВЭЭНСҮРЭН**



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно